БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ИНДРА

# 13, 16 ДУГААР ГУДАМЖНЫ ДУНД ХЭСГИЙН САЙЖРУУЛСАН ХАЙРГАН ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

| | |
|---|---|
| **1. Ерөнхий зүйл** | Обьектын нэр: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 13, 16 дугаар гудамжны дунд хэсгийн сайжруулсан хайрган хучилттай авто замын ажлын зургийн иж бүрдэл:<br>• Авто замын ажлын зураг<br>• Тайлбар бичиг<br>• Техникийн шаардлага<br>• Геологийн тайлан<br>• Геодезийн тайлан<br>• Инженерийн шугам сүлжээний зураг /гадна цахилгаан, гэрэлтүүлэг/<br>• Төсөв /Авто зам, гадна цахилгаан, гэрэлтүүлэг/<br>Уг зам нь нутаг дэвсгэрийн туслах гудамж замын ангилалд хамаарна. Авто замын ажлын зургийг “Танил санаа” ХХК боловсруулсан. |
| **2. Барилгын талбайн үзүүлэлт** | Одоо байгаа авто зам нь шороон зам бөгөөд шинээр хайрган хучилттай авто зам барина. |
| **3. Ажлын цар хүрээ** | Замын эхлэл буюу одоо байгаа асфальтбетон хучлагатай замтай уулзах уулзвар хэсэгт /ПК0+000-ПК0+015/ нэг зурвас нь 3.0м өргөн бүхий 2 эгнээ зорчих хэсэгтэй, 2 талдаа 1.0-1.5м өргөн хөвөөтэй нийт 9.0м-ийн өргөн далантай төлөвлөгдсөн байна.<br>Хучилтын хийц<br>- Өнгө асфальтбетон хучилт -5см<br>- Цементээр бэхжүүлсэн суурь -20см<br>- Хөлдөлтөөс хамгаалах үе -30см<br>/Тайлбар бичгийн нэг маягийн хөндлөн огтлол төрөл- II-оос үзэх/ |

| | |
|---|---|
| | Одоо байгаа авто зам нь шороон зам бөгөөд нэг зурвас нь 3.0м өргөн бүхий 2 эгнээ зорчих хэсэгтэй, 2 талдаа 1.5м өргөн шороон хөвөөтэй нийт 9.0м-ийн өргөн далантай төлөвлөгдсөн байна. /Тайлбар бичгийн нэг маягийн хөндлөн огтлол төрөл I-оос үзэх ПК0+015-ПК1+163.08/<br>Хучилтын хийц<br>• Зохист найрлага бүхий хайрган үе: h=25см<br>• Хөлдөлтөөс хамгаалах үе: h=30см<br>Авто замын трассын дагуу ус зайлуулах шуудуунд чулуун өрлөг бүхий бетон бэхэлгээ, зам доор ус зайлуулах ган хоолой /гарц d=0.3м, 14 цэгт/ туузан хашлага шинээр суурилуулах ажлууд төлөвлөгдсөн байна.<br>Авто замын трассын дагуу асфальтбетон, зохист найрлага бүхий хайрган хучилттай авто зам, цахилгааны шугам шилжүүлэх, гэрэлтүүлэг шилжүүлэх, гэрэлтүүлэг шинээр хийх ажлууд төлөвлөгдсөн байна. /ажлын зургаас нарийвчлан үзэх/<br>Авто замын барилгын ажлын тоо хэмжээг /тайлбар бичгээс үзэх/, авто замын гадна цахилгаан ба гэрэлтүүлгийн ажлын тоо хэмжээг салгасан тоо хэмжээгээр авах |
| **4. Ажлын хил хязгаар** | Замын байршил: Баянгол дүүрэг, 22 дугаар хороо, 13, 16-р гудамжны дундуур 1.16 км үргэлжилнэ /Ажлын зургаас байршлын зургийг үзэх/ |
| **5. Барилгын ажлын зохион байгуулалт** | 1) Барилга угсралтын ажлыг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал /түр зам, хаалт, тэмдэг тэмдэглэгээ г.м/ -ыг бүрэн хангаж ажиллана.<br>2) Гүйцэтгэгч байгуулага Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын даргын 2016 оны А/42 тоот тушаалаар батлагдсан “Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага” ыг засвар шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэх хугацаанд чанд мөрдөн ажиллана. Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан, холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд албан бичгээр хүргүүлнэ. Зааврын дагуу фото зургаар баримтжуулаагүй, 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайланд тусгагдаагүй ажилбар |

| | |
|---|---|
| | бүрийг гүйцэтгэлээс хасаж тооцно. Зурган баримтжуулалтад зориулалтын метр, рейк, гадас, самбар зэргийг ашиглана. Нөгөө талаас холбогдох БНбД-үүд, техник технологийн стандартуудад заасан шаардлагуудыг хангаж ажиллахыг анхаарна уу.<br>3) Тухайн засвар шинэчлэлтийн ажлыг хариуцан ажиллах инженер, техникийн ажилчид нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд энэ төслөөс өөр бусад төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч, хүн хүч, машин, механизмийн хуваарилалтын графикийг батлуулж ажиллана. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.<br>4) Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд үзэгдэхүйц газар байршуулна. Авто замын ажлыг батлагдсан төлөвлөгөө, аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчний графикийг хамтатган батлуулна. |
| **6. Бусад** | Шинээр баригдах хайрган замын барилгын ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө. |

**Хянасан:**

НАЗХГ-ын орлогч даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч — Д.Төрбилэг

НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч — О.Энхбаатар

**Боловсруулсан:**

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын
Бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн — Н.Энхтуяа

**Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай инженер техникийн ажилтан**

| № | Албан тушаал | Хүний тоо | Ажлын туршлага /жил/ |
|---|---|---|---|
| 1 | Ерөнхийи нженер /Авто замын инженер/ | 1 | 5 болон түүнээс дээш |
| 2 | Авто замын инженер | 1 | 3 болон түүнээс дээш |
| 3 | Геодезийн инженер | 1 | 2 болон түүнээс дээш |
| 4 | Материалын инженер | 1 | 2 болон түүнээс дээш |
| 5 | Хөдөлмөр хамгааллын инженер | 1 | 2 болон түүнээс дээш |
| 6 | Шугам сүлжээний инженер | 1 | 2 болон түүнээс дээш |

**Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай Машин механизмууд:**

| **No** | **Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр** | **х/н** | **Тоо** | **Хүчин чадал** | **Тайлбар** |
|---|---|---|---|---|---|
| 1 | Автогрейдер | шр | 1 | 140 м.х-с дээш | Өөрийн болон түрээс |
| 2 | Авто кран | шр | 1 | 16 тн | Өөрийн болон түрээс |
| 3 | Усны машин | шр | 1 | 5 тн-с дээш | Өөрийн |
| 4 | Эксковатор /дугуйт, молотоктой/ | шр | 1 | 0,5 м3 - 2 м3 | Өөрийн болон түрээс |
| 5 | Автосамосвал | шр | 4 | 7-9 м3 | Өөрийн |
| 6 | Авто ачигч | шр | 1 | 1.5-5м3 | Өөрийн болон түрээс |
| 7 | Индүү /доргиурт/ | шр | 2 | 10-18тн | Өөрийн |
| 8 | Хийн дугуйт индүү | шр | 1 | 5-8тн, 14-16тн, | Өөрийн |
| 9 | Индүү /Гөлгөр булт/ | шр | 1 | 5-8тн, 10-12тн, 18-20тн | Өөрийн болон түрээс |
| 10 | Бага оврын ачааны машин | шр | 1 | 3-5тн | Өөрийн |
| 11 | Асфальтбетон дэвсэгч /өргөний хэмжээ 7-9м/ | шр | 1 | 180 тн.цаг | Өөрийн болон түрээс |
| 12 | Авто гудронатор / цацагчаар тоноглогдсон байна/ | шр | 1 | 6000л | Өөрийн болон түрээс |

**Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай Тоног төхөөрөмжүүд:**

| No | Тоног төхөөрөмжийн нэр | Х/н | Тоо | Хүчин чадал | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Битумын тогоо /нүүдлийн/ | шр | 1 | | Өөрийн |
| 2 | Гүний болон талбайн вибратор | шр | 2 | 0.7-1.6м.х | Өөрийн болон түрээс |
| 3 | Зөөврийн гагнуурын аппарат | шр | 1 | 500а | Өөрийн болон түрээс |
| 4 | Компрессор | шр | 2 | 110м.х | Өөрийн болон түрээс |
| 5 | Нүүдлийн цахилгаан үүсгүүр | шр | 1 | 30 квт-аас багагүй | Өөрийн болон түрээс |
| 6 | Босоо дэвхэрдэг нягтруулагч | | 1 | | Өөрийн болон түрээс |
| 7 | Шөнийн цагт ажиллахад ашиглах талбайн гэрэлтүүлэг | ком | 1 | | Өөрийн болон түрээс |
| 8 | Замын хашлага тавих хайч /босоо, хэвтээ/ | шр | 8 | | Өөрийн |
| 9 | Гэрэл ойлгогчтой зөөврийн түмбэ, замын хаалт, зөөврийн тэмдэг, тууз, угсардаг хашаа | Хангалттайхэмжээгээр | | | |
| 10 | Бага оврын гар хөрс нягтруулагч төхөөрөмж | шр | 2 | 90кг, 120кг | Өөрийн |
| 11 | Автомат нивелир, Теодолит /сүүлийн үеийн/ | ком | 1 | | Өөрийн |
| 12 | Асфальтобетон зүсэгч болон чулуу зүсэгч хөрөө | шр | 1 | | Өөрийн |
| 13 | Талбайн дээрх ажлыг фото зургаар баталгаажуулахад шаардагдах багаж хэрэгсэл /Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага 2017-д тусгагдсан/ | ком | 1 | | Өөрийн |
| 14 | Нийтэд мэдээлэх самбар /2*3 / | ш | 1 | | Өөрийн |

**Хянасан:**

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Төрбилэг

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Засвар ашиглалт хяналтын хэлтсийн дарга Б.Цэрэнсодном

**Боловсруулсан:**

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Авто замын хяналтын мэргэжилтэн Ж.Бахберген

## УБ хот, Баянгол дүүрэг, 13.16-р гудамжын 1 км замын гадна цахилгаан, гэрэлтүүлгийн ажлын тоо хэмжээ

**/ Инж Ипок ХХК-ийн боловсруулсан ИНИ-14/16 дугаартай 2.2 км авто замын дагуух цахилгаан, гэрэлтүүлгийн зураг төслөөс 13,16-р гудамжны 1 км авто замын дагуух тоо хэмжээг салгаж авав /**

| 0.4 БА 10 КВ ЦДАШ | | |
|---|---|---|
| Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
| Хуучин 6-10 кв-ын агаарын шугамын 50мм2 оглолтой утасыг шилжүүлэн татах | км (3 утас) | 0.06 |
| Шинээр 6-10 кв-ын агаарын шугамын 50мм2 оглолтой утасыг татах | км (3 утас) | 0.02 |
| 0.4 кВ-ын шонгийн нүхнүүдийн цэгийг тэмдэглэж гадас зоох | 1тулгуур | 3 |
| 0.4кВ-ын тулгуур шилжүүлэн суурилуулах-3 тулгуур | ш | 1.5 |
| Хэвийн нөхцөлд төмөр бетон завсарын тулгуур шинээр угсрах | ш | 1 |
| Шинээр 0.4 кв-ын агаарын шугамын бүрээстэй 3х50+1х54 мм2 сип утас тулгуурт татах | км | 0.02 |
| Хуучин 0.4 кв-ын агаарын шугамын бүрээстэй 3х50+1х54 мм2 сип утас тулгуурт татах | км | 0.07 |
| Тулгуурт газардуулгын буулт хийх | 1 тулгуур | 4 |
| Газардуулгын шинийг сунгаж шуудуунд тавих | м | 1200 |
| Газардуулгын электрод зоох Ф22 2*2.5 | ш | 24 |
| Тулгуурын нүхийг гараар ухах | м3 | 13.2 |
| Тулгуурын нүхийг эргүүлж булах | м3 | 11.3 |
| Газардуулгын шуудууг экскаватороор ухах | м3 | 59.8 |
| Газардуулгын шуудууг гараар ухах | м3 | 10.4 |
| Шуудууг эргүүлж булах | м3 | 59.8 |

| 2.ГАДНА ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ | | |
|---|---|---|
| Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
| Шонгийн нүх экскаватороор ухах | м3 | 53.15 |
| Шонгийн нүх гараар ухах | м3 | 9.32 |
| Гадна талбайн 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч шилжүүлэн суурилуулах-27 шон | ш | 14.5 |
| Гадна талбайн 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч шинээр суурилуулах | ш | 2 |
| Өндөр хүчин чадалтай нураах алхаар хуучин бетон суурийг задлаж бүүлгах | м3 | 13.73 |
| Шонгийн бетон суурь цутгах | м3 | 14.21 |
| 0.4 кв-ын 3х16+1х25 мм2 сип утас буулгаж шилжүүлэн суурилуулах | км | 0.344 |
| 0.4 кв-ын 3х16+1х25 мм2 сип утас шинээр татах | км | 0.0305 |
| Баригч суулгах | ш | 2 |
| Шонгийн нүх эргүүлж булах | м3 | 53.15 |

Тоо хэмжээ тодорхойлсон : Зургийн инженер М.Мөнхбаатар

Тоо хэмжээ хянасан : Авто замын зургийн ерөнхий инженер З.Цэндмаа

ТАНИЛ САНАА ХХК
XTO2327
5194342
УЛААНБААТАР ХОТ